




**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**“ХҮҮХДИЙН ЗУСЛАНГИЙН ХУВЬЧЛАЛ,
ХУУЛЬ ТОГТООМЖИЙН НИЙЦЭЛ”-Д
ХИЙСЭН НИЙЦЛИЙН АУДИТЫН
ХУРААНГУЙ ТАЙЛАН**

2023 он

ХҮҮХДИЙН ЗУСЛАНГИЙН ХУВЬЧЛАЛ, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН НИЙЦЭЛД ХИЙСЭН НИЙЦЛИЙН АУДИТ



Хүүхдийн зуслангийн
хувьчлал хууль тогтоомжид
нийцсэн эсэхэд нийцлийн
аудит хийж, дүнг
холбогдох байгууллага,
албан тушаалтанд
танилцуулах

01 Хүүхдийн зусланг хувьчилсан
шийдвэрүүд холбогдох хууль, тогтоомжид
нийцсэн эсэх

02 Хүүхдийн зусланг хувьчлах үйл
ажиллагаа холбогдох хууль, тогтоомжийн дагуу
явагдсан эсэх

03 Хувьчилсан шийдвэр, гэрээний
биелэлтийг дүгнэж, үр дүнг нь тооцсон эсэх


ХҮҮХДИЙН ЗУСЛАНГИЙН ХУВЬЧЛАЛ, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН НИЙЦЭЛД ХИЙСЭН НИЙЦЛИЙН АУДИТ



ХҮҮХДИЙН ЗУСЛАНГИЙН ХУВЬЧЛАЛ, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН НИЙЦЭЛД ХИЙСЭН НИЙЦЛИЙН АУДИТ



Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 5 дугаар баг, Уулзварын голын ойролцоо үйл ажиллагаа явуулж байсан “Сансар зуслан” 32 дугаар бааз /Баянхайрхан ХК/-ийн харьяанд 1997 он хүртэл, 1997-2009 он хүртэл “Хүүхдийн төлөө төв”-д харьяалагдаж байсан байна.



“Сансар” хүүхдийн зусланг Шивээговь сумын “Мандал Сансар” хоршооноос ирүүлсэн хүсэлтийн дагуу 2004 онд менежментийн хувьчлалаар 3 жилийн хугацаатай шилжүүлсэн байна.



“Сансар” хүүхдийн зусланг менежментийн гэрээний үр дүнг харгалзан 20 хувийн орон нутгийн өмчийн оролцоотойгоор өөрчлөн зохион байгуулах, хувьчлах шийдвэр гаргасан байна.



“Сансар” хүүхдийн зусланг 100 хувь иргэн Ж.Бадамжавт өмчлүүлэх шийдвэр гарч, үл хөдлөх эд хөрөнгө худалдан авах гэрээ байгуулж, 711.2 мянган төгрөгөөр худалдан борлуулсан байна.

2023 он

ХҮҮХДИЙН ЗУСЛАНГИЙН ХУВЬЧЛАЛ, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН НИЙЦЭЛД ХИЙСЭН НИЙЦЛИЙН АУДИТ



- Төрийн өмчийн эд хөрөнгөд бүртгэлтэй хүүхдийн зусланг менежментийн гэрээгээр хувьчлахад төсөл сонгон шалгаруулалт явуулаагүй байна.
- Хүүхдийн “Сансар” зусланг хувьчлахтай холбоотой гаргасан шийдвэр хууль, тогтоомжид нийцээгүй байна.
- Зуслангийн газрыг Газрын тухай хуулийг зөрчиж, газрын төлбөр ногдуулалгүйгээр үнэ төлбөргүйгээр эзэмшүүлсэн байна.



- Хувьчлах үйл ажиллагааны сонгон шалгаруулалтай холбоотой баримт материал байхгүй байна.
- Хүүхдийн “Сансар” зусланг хувьчлахдаа зах зээлийн үнэлгээг бодитоор тооцоогүй, дансны үнийн 20%-иар тооцож, төрийн өмчийг үнэгүйдүүлсэн байна.



- Менежментийн гэрээгээр хүлээсэн үүргээ оролцогч талууд хэрэгжүүлээгүй байна.
- Менежментийн гэрээний хэрэгжилт, үр дүнг бодитой дүгнээгүй, зуслангийн хувьчлалд аймгийн Аудитын газрын дүгнэлтийг харгалзан үзээгүй байна.
- Хүүхдийн Сансар зусланг иргэнд хувьчлан өмчлүүлснээс хойш өмчлөгч 2 удаа солигдсон ба зуслангийн үйл ажиллагааг огт явуулаагүй байна.
- Зуслангийн зориулалтаар олгосон газрыг зориулалтын дагуу ашиглаагүй, хувьчлал хийгдсэнээс хойш 2010-2021 оныг хүртэлх 11 жилийн хугацаанд газрын төлбөрийн ногдуулалт хийгээгүй, эрх бүхий байгууллагаас хяналтыг хэрэгжүүлээгүй, орлогыг төсөвт төвлөрүүлээгүй байна.
- Хувьчилснаас хойш холбогдох чиг үүрэг бүхий төрийн байгууллагууд хяналт тавьж ажиллаагүй, төр хувийн хэвшил хоорондын хамтын ажиллагааг хэрэгжүүлээгүй байна.

Бүлэг 1

Бүлэг 2

Бүлэг 3

ЗӨВЛӨМЖ

Сүмбэр сумын Засаг даргад

Хүүхдийн “Сансар” зуслангийн газрыг эзэмшигч иргэн Я.Өлзийболдтой байгуулсан газар эзэмшүүлэх гэрээг жил бүр дүгнэх, гэрээг шинэчлэн байгуулах, гэрээнд заасан зориулалтын дагуу ажиллуулах талаар холбогдох арга хэмжээг авах /гэрээг хариуцлагатай байгуулах, эрх үүрэг, хариуцлагыг сайтар оруулах/

Аймгийн ГХБХБГ-ын даргад

Газрын тухай хуулийг зөрчиж, газрыг үнэ төлбөргүйгээр эзэмшүүлж, хувьчлал хийгдсэнээс хойш 2010-2021 оныг хүртэлх 12 жилийн хугацаанд газрын төлбөрийн ногдуулалт хийгээгүй, эрх бүхий байгууллагаас хяналтыг хэрэгжүүлээгүйгээс төсөвт төвлөрүүлээгүй орлогыг нөхөн төлүүлэх ажлыг зохион байгуулах

2023 он



АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

Дэлгэрэнгүй дараах холбоосоор орж үзнэ үү.
www.audit.mn